

# “БЛЭК ЭНД ВАЙТ ДРИЙМ” ХХК



УЛААНБААТАР ХОТЫН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 11 ДҮГЭЭР  
ХОРООНЫ НУТАГТ БОГДХАН УУЛЫН ДЦГ-ЫН ХҮРЭЛТОГООТЫН  
АМАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ “БУУДАЛЛАХ, ОТОГЛОХ, ОРОН БАЙР  
БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

РД: 6136974

## ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	12
2.1 Цаг уур .....	12
2.2 Гадаргын болон гүний ус .....	12
2.3 Хөрсөн бүрхэвч .....	13
2.4 Амьтны аймаг .....	15
2.5 Түүх соёлын дурсгалт газрууд.....	16
2.6 Тусгай хамгаалалттай газар нутаг .....	17
2.7 Нийгэм эдийн засаг.....	18
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	20
3.1 Төслийн барилга байгууламжийг өргөтгөн барьж байгуулах үеийн гол нөлөөлөл.	23
3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл .....	23
3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл .....	24
3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл.....	25
3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл .....	26
3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл .....	26
3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл.....	27
3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл.....	27
3.9 Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл.....	28
3.10 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	32
3.11 Хуримтлагдах нөлөөлөл.....	32
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	34
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	35
ЗУРГАА.ОРЧНЫ ТОХИЖИЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	39
ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	39
НАЙМ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ... <b>Error! Bookmark not defined.</b>	
ЕС.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ .....	40
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	41
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	43
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	44

## **ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Газарзүйн солбицол.....	4
Хүснэгт 2. Ахуйн ундны усны тооцоо.....	9
Хүснэгт 3. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт.....	13
Хүснэгт 4. Хөрсний механик бүрэлдэхүүн.....	14
Хүснэгт 5. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар.....	14
Хүснэгт 6. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж.....	14
Хүснэгт 7. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа.....	20
Хүснэгт 8. Гол нөлөөллийн дүн шинжилгээ.....	21
Хүснэгт 9. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ.....	24
Хүснэгт 10. Автомашины утааны бүрдэл найрлага.....	25
Хүснэгт 11. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	31
Хүснэгт 12. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл.....	33
Хүснэгт 13. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	35

## **ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Цахилгаан хангамжийн төлөвлөлт.....	7	
Зураг 2. Цэвэр бохир ус, халаалтын шийдэл.....	9	
Зураг 3. Дулаан хангамжийн шийдэл.....	10	
Зураг 4. Хур тунадасны үзүүлэлт	Зураг 5. Уур амьсгалын үзүүлэлтүүд.....	12
Зураг 6. Туул голын ус зүй.....		13
Зураг 7. Богдхан уулын амьтны аймаг.....		16
Зураг 8. Богдхан уулын ДЦГ-ын ойн сан.....		17
Зураг 9. Улаанбаатар хотын газар ашиглалт.....		19
Зураг 10. Богдхан уулын ДЦГ-ын ойн сан.....		29

## **НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Төслийн нэр : “Буудаллах, отоглох, орон байр” байгуулах төсөл



*Зураг 1. Төслийн ерөнхий төлөвлөгөө*

### **Төслийн зорилго:**

Энэхүү төслийн зорилго нь гадаад болон дотоодын аялагч амрагчид эрүүл агаар, байгалийн сайханд гэр бүл, найз нөхөд, хамт олноороо амрах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлсэн, жилийн дөрвөн улиралд тогтвортой ажиллах, байгальд ээлтэй амралтын газар байгуулж чанартай найдвартай найрсаг үйлчилгээгээрээ хэрэглэгчдийн талархлыг хүлээсэн амралтын газар болж хөгжих юм.

### **Төслийн байршил:**

“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн Буудаллах, отоглох, орон байр байгуулах төсөл нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлана. Талбайн хэмжээг 60000 м<sup>2</sup> байхаар төлөвлөжээ.

*Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:*

*“Блэк энд вайт дрийм” ХХК*

*ААН-ийн УБД, РД:*

*УБД: 9011650044 РД: 6136974*

*Одоо ашиглаж буй хэлбэр :*

*Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.*

*Газрын зориулалт:*

*Аялагч, зөвшөөрөл бүхий хүн түр буудаллах, отоглох зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах*

*ААН-ийн албан ёсны хаяг:*

*УБ, Хан-Уул, 11-р хороо, 3 хэсэг, энхжин хотхон, 32д, 23 тоот. Утас: 89088670, 75751712*



Хүснэгт 1. Газарзүйн солбицол

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	3	36.007	47	52	22.327
2	107	3	39.040	47	52	25.320
3	107	3	44.780	47	52	18.760
4	107	3	42.765	47	52	15.016
5	107	3	40.044	47	52	08.936
6	107	3	38.070	47	52	05.920
7	107	3	34.560	47	52	06.780
8	107	3	36.815	47	52	13.721
9	107	3	38.650	47	52	19.370



Зураг 2. Төсөл хэрэгжих байршлын зураг



Зураг 3. Төслийн талбайн сансрын зураг

**Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал :**

“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн буудаллах, отоглох, орон байр нь А загварын отоглох байр-12 /1800м<sup>2</sup>/, В загварын отоглох байр-19 /2622м<sup>2</sup>/, С загварын отоглох байр-19 /1976м<sup>2</sup>/, Үйлчилгээний барилга-1 /1280м<sup>2</sup>/ нийт 51 барилга байгууламж баригдахаар төлөвлөсөн.

**Барилга байгууламжийн төлөвлөлт**



Буудаллах, отоглох орон байрны үйлчилгээний барилга





Баригдах амралтын газрын орон байрны А блок



Баригдах амралтын газрын орон байрны В блок



Баригдах амралтын газрын орон байрны С блок




Талбай доторх булаг хамгаалах төлөвлөлт

**Ажиллах хүч:** Нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.

**Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал**

**Цахилгаан хангамж** – Буудаллах, отоглох, орон байр нь төвийн эрчим хүчний эх үүсвэрт холбогдолгүйгээр, тусдаа цахилгаан үүсгэгч генератор ажиллуулах нь цахилгааны

хэрэглээг хангахад хүрэлцэхүйн зэрэгцээ өндөр зардалтай, түлш шатахуун зарцуулж хорт угаа ялгаруулах, байгаль орчинд халтай нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзсэн тул амралтын газрыг төвийн цахилгаан сүлжээнд холбохоор төлөвлөсөн. Үүний тулд цахилгаан шугам татах шаардлагатай ба хөрөнгө оруулалтаар зардлыг шийднэ.



Зураг 1. Цахилгаан хангамжийн төлөвлөлт

Төсөлд шаардлагатай цахилгаан эрчим хүчийг “Нийслэл түгээх сүлжээ” газраас цахилгааны техникийн нөхцөл авч, төслийн талбайгаас 2.5 км зайтай эх үүсвэрээс 10 кВ агаарын цахилгаан дамжуулах шугам татахаар төлөвлөсөн.

Мөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг давхар ашиглахаар төлөвлөж байна.

Тус төслийн хүрээнд эрчим хүч татуулахдаа дараах нөхцөлүүдийг бүрэн хангасан байх шаардлагатай. Үүнд:



Харьяа Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр ирж цахилгаан хангамжийн 220В, 0.4 кВ түүнээс дээш хүчдэлийн сүлжээнд шинээр холбогдох өргөдлийг бөглөж, түүнд заагдсан бүрдүүлэх материалыг “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвд бүрдүүлэн өгч бүртгүүлнэ.

- Өргөдөл
- Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
- Газрын гэрчилгээ,
- Газрын байршлын кадастрын зураг,
- Архитектур төлөвлөлтийн даалгавар, эх зураг гэх мэт-г бэлтгэнэ. Тодруулах хуудсыг үнэн зөв бүрэн бөглөсөн байх шаардлагатай.

Өргөдлийг хүлээн авснаар аж ахуй нэгж байгууллага нь нэмэлтээр шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлнэ. Үүнд:

№	380В	220В
1	Техникийн нөхцөл	Техникийн нөхцөл
2	Холболтын протокол	Газардуулгын протокол /Орон сууцны болон ерөнхий шитнээс холбогдсон бол шаардлагагүй/
3	Газардуулгын протокол	Тоолуурын гэрчилгээ
4	Тоолуурын гэрчилгээ	Байгууллагын гэрчилгээний хуулбар
5	Гүйдэл, хүчдэлийн трансформаторын гэрчилгээ	Харилцах утасны дугаар
6	Газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар	Газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар
7	Байгууллагын гэрчилгээний хуулбар	
8	Харилцах утасны дугаар	

**Цэвэр усан хангамж** - Худаг гаргах зөвшөөрөл авч шинээр худаг гаргасан. Худгийн паспорт, усны шинжилгээ, худаг гаргах зөвшөөрөлийг хавсралтаар оруулав.

**Зөвлөмж:**

- Төсөл хэрэгжих талбайд худаг гаргахдаа холбогдох шатны байгууллагаас зөвшөөрөл авч усны мэргэжлийн байгууллагаар худаг гаргуулан ус дамжуулах шугамын оролт тус бүр дээр тоолуур суулгах, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, дүгнэлт гаргуулан цаашид ажиллах шаардлагатай.
- Төсөл хэрэгжих эзэмшил болон хариуцан хамгаалах талбайг үерийн болон гадаргын усны урсцаас хамгаалах зорилгоор далан байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах
- Үерийн уснаас хамгаалах даланг төслийн барилга байгууламжийн зураг төсөлд тодорхой тусгуулж хэрэгжүүлэх,

Тус төслийн хүрээнд усан хангамж хэрэглэхдээ дараах нөхцөлүүдийг бүрэн хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Өргөдөл, албан хүсэлт
- Иргэний үнэмлэх, Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
- Гүний худаг ашигладаг бол Худгийн зөвшөөрөл, худгийн паспортын хуулбар
- Танилцуулга, Байгууллагын танилцуулга
- Дүгнэлт- Туул голын сав газрын захиргаа, эсвэл байгаль орчин аялал жуулчлалын яамны дүгнэлтийн хуулбар
- Кадастрын зураг

Төслийн багт байнгын 27 ажилчинтай байна. Ажилчид кемпэд байрлаж, унд ахуйн усны хэрэглээг ариутгах татуургын системээр холбогдсон өөрийн гүний худгаас хангах

бөгөөд ундны усанд сар бүр эрдэсийн болон бактертологийн шинжилгээ хийж, хяналт тавьж байх шаардлагатай.

*“Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 14 дүгээр хавсралт “Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм”-д зааснаар амралт сувиллын газарт 1 амрагчийн хоногийн дундаж усны хэрэглээ нь 180 л болно.*

*Хүснэгт 2. Ахуйн ундны усны тооцоо*

№	Үзүүлэлтүүд	Норм, л/хоног	Хамрах нэгж	Усны зарцуулалт		
				Хоногт хэрэглэх ус м <sup>3</sup> /хоног	Жилд ажиллах хоног	м <sup>3</sup> /жил
1	Ахуйн усны хэрэглээ	180	29хүн	5.22	365	1905.3
2	Амрагчид	180	350хүн	63.0	365	22995
3	Ногоон байгууламж усалгаа	40л/1ш	150ш	6.0	24	144.0
<b>Нийт</b>			-	<b>74.22</b>	<b>365</b>	<b>25044.3</b>

Буудаллах, отоглох, орон байр нь цэвэр бохир ус, халаалтаа “Bauhaus” компанийн нийлүүлж байгаа Герман технологийн иж бүрэн бие даасан системээр хийхэр төлөвлөж байна.




*Зураг 2. Цэвэр бохир ус, халаалтын шийдэл*

- Германы Heider брендийн 1000л багтаамжтай ган даралтат сав нь худгаас татан нэмэлт насос шаардахгүй өөр дээрээ даралт үүсгэн нөөцөлсөн цэвэр усаа нэмэлт насосгүйгээр 3-5.5 бар даралттайгаар шахна.
- Савнаас гарах усыг италийн Atlas Filtri брендийн 90 микро м-н элс хогны шүүгч боон биологи бохирдолын шүүгчээр шүүж түгээнэ. Нэмэлтээр ус зөөлрүүлэгч систем тавина.

**Харилцаа холбоо** – Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь үүрэн телефоны бүхий л сүлжээ ашиглах боломжтой бөгөөд үйл ажиллагаандаа дотоод сүлжээгээр барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын системийг ашиглана. Төсөлд агааржуулалт, кабелийн телевиз зэргийг хамруулж иж бүрэн автомат сүлжээ бий болгоно. Мөн цогцолборын удирдлагын системд зориулан ажиллагсадтайгаа холбогдох явуулын станцыг суурилуулна.

**Хаягдал бохир усны шийдэл** – Тус буудаллах, отоглох, орон байр нь “Bauhaus” компаний нийлүүлж буй бүрэн биологийн цэвэрлэгээ бүхий SBR технологийн Кларифокс цэвэрлэх байгууламжийг ашиглана.



*Тус байгууламж нь ахуйн хэрэгцээнээс гарсан бохир, усыг 98% цэвэршүүлдэг бөгөөд цэвэршсэн усыг ахин ашиглаж, ногоон байгууламж услах, байгалийн усан санд нөөцлөх, эсвэл хөрсөнд шингээх байдлаар ажилладаг. Энэхүү төхөөрөмжийг ашигласнаар бохир усыг шууд байгаль хаяж бохирдуулах, эсвэл бохирыг соруулж, тээвэрлэх зэрэг зардал ихтэй, хоцрогдсон арга барилаас татгалзах боломж олгоно. Цэвэршүүлж байгальд шингээх ус нь “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус” МУ-н стандарт MNS 4943:2011-г хангасан байна.*

**Дулаан хангамж:** Буудаллах, отоглох, орон байрны халаалт, дулааны эх үүсвэрийг сонгохдоо байгаль орчинд ээлтэй байдал, ашиглах, ажиллуулахад төвөг багатай байдал, үр ашигт ажиллагаа, ашиглалтын үеийн зардал, хэрэглээндээ тохируулан зохицуулах боломж зэргийг харгалзан үзэж амралтын газрын халаалтыг бүхэлд нь цахилгаан халаалт ашиглахаар төлөвлөсөн.



*Зураг 3. Дулаан хангамжийн шийдэл*

Энд мөн “Bauhaus” компаний нийлүүлж буй цахилгааны хэмнэлттэй, найдвартай автомат ажиллагаатай германы “Vaillant” компаний “Protherm” брэндийн цахилгаан халаалтын тогоог амралтын байр болон ажилчдын байранд тус бүр 100- 120м<sup>2</sup> халаах хүчин чадалтай 9-12kw-н цахилгаан зуух суурьлуулна.

*Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 01-ний өдрийн А/331 “Аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалын дагуу хүлэмжийн хийг бууруулах зорилгоор эрчим хүчний шийдлийг байгальд ээлтэй технологи ашиглаж халаалт, дулааны*

асуудлыг шийдвэрлэх боломжийг төсөлд тусгасан эсэх гэсэн шаардлагад нийцүүлэн дараахь шийдлүүдийг зөвлөмжүүдийг тусгаж байна. Үүнд:

- Сэргээгдэх эрчим хүчний цахилгаан үүсгүүр болох нарны дэлгэц ашиглах
- Дулаан хангамжийг цахилгаан халаагуураар шийдэх
- Сайжруулсан шахмал түлш хэрэглэх зэрэг шийдлүүдийг зөвлөж байна

**Зам харилцаа** – Тус төсөл нь Богдхан уул, Хүрэлтогоотын амны бэлд байрлах тул зам харилцаа сайн хөгжсөн юм.

**Зөвлөмж:** Төсөл орчмын талбай, автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох, мөн төслийн газраас төв зам хүртэлх шороон замыг хатуу хучилттай болгохыг зөвлөж байна.

**Ариун цэврийн өрөө** – Тус төсөл нь нэгдсэн дотоод ариун цэврийн өрөө гаргаж хангах хаягдал бохир усыг орчин үеийн хамгийн сүүлийн байгаль орчинд хор нөлөөгүй дэвшилтэт технологи хэрэглэнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь “Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд”-ын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн А/331 тоот тушаалын дагуу байгаль орчинд халгүй, хөрсний бохирдол үүсгэдэггүй ариун цэврийн байгууламж, төслийн цар хүрээнээс хамааран бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах шаардлагатай.

#### **Төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хугацаа**

“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн буудаллах, отоглох, орон байр байгуулах төсөл нь 2024-2027 онд барилга, байгууламж бүрэн баригдаж дуусах ба жилийн дөрвөн улиралд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулна.




## ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


### 2.1 Цаг уур

Төсөл хэрэгжих орчимд эх газрын уур амьсгалын онцлогоос болоод жилийн хүйтэн улиралд агаарын температур газар өндөрсөх тутам дулаарах, харин дулаан улиралд газар өндөрсөх тутам сэрүүсдэг байдал энд тодорхой харагдаж байгаа бөгөөд “хотын дулаан арал” тод илэрч байдаг онцлогтой.

Зураг 4. Хур тунадасны үзүүлэлт



Зураг 5. Уур амьсгалын үзүүлэлтүүд




Аливаа төслийн төлөвлөлтөнд тухайн төсөл хэрэгжих орчны байгаль цаг уурын онцлог, уур амьсгалын хүчин зүйлийг судалж, нарийн сайн тооцоолох хэрэгтэй. Харин тус төслийн хувьд хэрэгжих орчин нь эрс тэс уур амьсгалтай, агаарын болон хөрсний температур сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай, тухайн орчны агаарын хуурайшилт эрчимжиж байна. Хавар, намрын улиралд салхины хурд ихэсч, шороон шуургын давтамж нэмэгдэх, салхины нөлөөгөөр ууршилт нэмэгдэж, хуурайшилт эрчимжихийг цаашдын үйл ажиллагааны төлөвлөлтөнд харгалзан үзэх шаардлагатай.

### 2.2 Гадаргын болон гүний ус

Төслийн талбай нь Дэлхийн ус хагалбарын Хойд мөсөн далайн ай савд, Монгол орны 29 голын сав газрын Туул гол болон Хараа голын сав газарт хамаарагддаг. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадаргын усан сүлжээ нэлээд сайн хөгжсөн байдаг. Тухайлбал, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хамгийн том гадаргын усан сүлжээний илэрц нь Туул гол юм.

Туул голын тэжээлийн 25%-ийг ул хөрсний ус, 6%-ийг хайлсан цасны ус, 69%-ийг хур борооны ус эзлэх ба усны горимын хэв шинж нь хаврын шар усны ба зуны хур борооны үеийн горимтой голд хамаарна. Туул голын урсац бүрдүүлэх үндсэн хүчин зүйл бол хур тунадас болно. Туул голын усны үндсэн тэжээл зун, намрын хур бороо болохоор усны түвшин ихээхэн тогтворгүй байдаг. 4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр хаврын шар усны үер ажиглагдах боловч үргэлжлэх хугацаа, урсцын хэмжээгээр бага юм. Хаврын шар усны үерийн дараагаар нэг хэсэгтээ зуны гачиг үе ажиглагдах бөгөөд 7-9 дүгээр сар хүртэл зун, намрын борооны үер залгаснаар голын усны түвшин эрс дээшилнэ.



Зураг 6. Туул голын ус зүй

Борооны үерийн түвшин шар усны үерийн түвшингээс 1.5-2.0 дахин их байдаг. Хур борооны үер дууссаны дараа мөсний үзэгдэл үүсэх хүртэл усны түвшин аажим буурч өвлийн гачиг үе эхэлнэ.

Туул голын сав газарт хамаарах Туул голын усны химийн найрлагын үндсэн эх үүсвэр нь голын сав газрын уулын чулуулаг боловч, цэгийн бохирдлын үүсвэрийн нөлөөгөөр давамгайлах ионууд болон ионы харьцаанд ихээхэн өөрчлөлт орж байна. Туул голын усны химийн найрлага, бохирдуулагч үзүүлэлтүүдийн хэлбэлзэл, жилийн доторхи хуваарилалт нь голчлон үндсэн урсац, хайлсан цас, мөс, гадаргын угаагдал, хур борооны усны сүлэгдэл холилдлыг харуулж байгаа боловч, голын ихээр бохирдсон хэсэгт урсацын хэмжээ өөрөөр хэлбэл, голын услагаас шууд шалтгаалдаг байна.

Төслийн талбайн хойд талд Туул гол урсаж байгаа учраас төслийн үйл ажиллагааны улмаас гадаргын усанд нөлөөлөх боломжтой. Төслийн зүгээс гүний усанд үзүүлж болзошгүй нөлөөлөлд усыг барилгын ажил, тоос дарах болон ахуйн зориулалтаар ашигласнаас зэргээс гүний усны түвшин тодорхой хэмжээгээр буурах нөлөөлөлд орно. Гүний болон гадаргын ус нь барилгын болон ашиглалтын шатанд шатахуун тослох материалын алдагдал, хог хаягдалаас бохирдож болзошгүй.

### 2.3 Хөрсөн бүрхэвч

Энэхүү бүлэгт Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Богдхан уулын ДЦГ нутгийн Хүрэлтогоотын аманд байрлах 60000 м<sup>2</sup> аялал жуулчлалын зориулалттай газарт хийсэн хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнг тусгав.

#### Судалгааны үр дүн

Төсөл хэрэгжих талбай нь газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт хамаарна.

Хүснэгт 3. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

Зүсэлт	Гүн, см	рН Н <sub>2</sub> О	ЦДЧ, dS/m	Ялзмаг %	Са CO <sub>2</sub> , %	Шим гэжээлийн элементүүд мг/100 гр	
						P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
1	0-30	7.95	0.177	2.615	3.64	2.04	23.8

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, дунд зэргийн карбонаттай, ялзмагийн агууламж дунд, дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж дунд болон калийн хангамж их байна.

### **Хөрсний механик бүрэлдэхүүн**

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

*Хүснэгт 4. Хөрсний механик бүрэлдэхүүн*

ГГүн, см	Механик бүрэлдэхүүн, % ширхгийн хэмжээ, мм		
	Элс (2-0.0мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (<0.002мм)
0-15	58.5	30.6	10.9

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

*Хүснэгт 5. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар*

Хөрсний шинж чанарын үзүүлэлт		Механик бүрэлдэхүүн		
		Элсэнцэр ба хөнгөн шавранцар	Дунд шавранцар	Хүнд шавранцар, шавар
1	Боловсруулалт	++	+	- -
2	Тэжээлийн бодис агуулалт	- -	+	++
3	Ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт	-	++	+
4	Хоруу бодисын хуримтлал	-	++	++
5	Ус агуулалт	- -	++	++
6	Ургамал ус нийлүүлэлт	-	+	-
7	Механик шүүлт	+	+	-
8	Физик-химийн шүүлт	- -	++	+
9	Ус шүүлт	++	0	- -

\*++ маш сайн (дээд зэрэг), + сайн (өндөр), 0 хангалттай (дунд зэрэг), - тааруу, - - нэн хангалтгүй

Дээрх хүснэгтээс үзэхэд элсэнцэр ба хөнгөн шавранцар хөрс нь тэжээлийн бодис, ус агуулалт болон физик химийн шүүлт нэн хангалтгүй, ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт, хоруу бодисын хуримтлал, ургамлын ус нийлүүлэлтээр тааруу харин механик шүүлт сайн, хөрсний боловсруулалт, ус шүүлтээр маш сайн гэсэн үзүүлэлттэй байна.

### **Хөрсний бохирдол**

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын 1 дээж авч “Инженер геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 6. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж*

№	Үзүүлэлт	Агууламж мг/кг	Хөрсний механик бүрэлдэхүүн			Хөрсний хүнд металлын агууламж, %		
			Шаварлаг	Шавран цар	Элсэрхэг	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Хортой агууламж	Аюултай агууламж
1	Никель (Ni)	5.0	150	100	<b>60</b>	150.0	1000.0	1800.0
	Кадми (Cd)	ND	3	2	<b>1</b>	3.0	10.0	20.0
	Хар тугалга (Pb)	ND	100	70	<b>50</b>	100.0	500.0	1200.0
	Цайр (Zn)	15.4	300	150	<b>100</b>	300.0	600.0	1000.0
	Хром (Cr)	0.3	150	100	<b>60</b>	150.0	400.0	1500.0
	Зэс (Cu)	10.6	100	80	<b>60</b>	100.0	500.0	1000.0

Хөрсний дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг (MNS 5850:2020) Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад хүлцэх, хортой болон аюултай агууламжаас доогуур буюу хөрс бохирдолгүй байна.

MNS 5850:2020 стандарт нь хөрс бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээний 3 зэрэглэлд хуваадаг. Үүнд:

- Хүлцэх агууламж
- Хортой агууламж
- Аюултай агууламж

*Хүлцэх агууламж:* бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах хэмжээ нь хүлцэх агууламжаас дээш гарсан тохиолдолд хөрс бохирдолтын түвшинд хүрсэн гэж үзнэ. Хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь адил утгатай. Хүлцэх агууламжийг хүн ам оршин суудаг суурин газар, хөдөө аж ахуйн эдэлбэр, газар тариалан, бэлчээрийн эдэлбэр газруудад мөрдлөг болгоно.

*Хортой агууламж:* хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементийн хэмжээ нь хортой агууламжаас давсан тохиолдолд тухайн хөрс нь орчин тойронд байгаа амьд организм, усан давхаргад хортой аюул учруулж эхэлнэ. Хортой агууламжийг тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэл, уул уурхайн бүсэд бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй адил утгаар мөрдлөг болгоно.

*Аюултай агууламж:* хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементийн хэмжээ нь аюултай агууламжаас давсан тохиолдолд хөрсний бохирдлыг арилгах яаралтай арга хэмжээ авах шаардлагатай. Тухайлбал саармагжуулах, ухааж зайлуулах, газар ашиглалтын үйл ажиллагааг зогсоох, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх гэх мэт.

### **Хөрсний элэгдэл**

Төслийн талбайд одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

### **Дүгнэлт**


Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн муж, Хэнтийн төвийн тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009). Уулын хар шороон хөрс нь далайн түвшнээс дээш 1412.8- 1533.3 метрийн үнэмлэхүй өндөрт, уулс хоорондын хөндийд байрласан байна. Газрын гадаргын налуу буюу хэвгийн 6.7<sup>0</sup>-16.8<sup>0</sup> (градус) байна. Шинжилгээний үр дүнгээс үзэхэд уг талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь химийн бохирдолгүй байна.

### **2.4 Амьтны аймаг**

Төслийн талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Хэнтийн уулын тайгын тойрогт багтана. Богдхан уул амьтны газарзүйн хувьд тайга, ойт хээр, хээр тал, ус намаг, хад асга, хот суурин, интрузиаль янз бүрийн ландшафт,



амьдралын экологийн олон онцлогуудыг агуулснаараа шавьж, шувуу, хөхтөн амьтдын өвөрмөц баазтой байсан боловч сүүлийн жилүүдийн аялал жуулчлалын бааз, баазуудын суурьшил, Богдхан уулын ДЦГ-ын аялал зугаалга зэргээс ан амьтан үргэн дайжсан байдалтай байна. Зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу, бичил биетэн зэрэг амьтад байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөнтэй холбоотой.



Зураг 7. Богдхан уулын амьтны аймаг

Төсөл хэрэгжих үед амьтны аймгийг ажиглаж хяналт явуулах нь тухайн бүс нутгийн амьтны аймгийн талаар шинжлэх ухааны мэдээ баримтыг цуглуулах боломж олгоно. Төслийн талбайн ойролцоо амьдрах амьтдад дуу чимээ, тоосны бохирдолоор шууд нөлөө үзүүлснээр амьдрах орчноо алдах үргэж дайжиж болзошгүй. Төслийн барилгын ажлаас үүсэх нүх, тээврийн хөдөлгөөн ихэссэнээр осол гарч болзошгүй.

## 2.5 Түүх соёлын дурсгалт газрууд

Богдхан уулын дархан цаазат газрын нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 41651 га бөгөөд дотроо онгон, хамгаалалтын, хязгаарлалтын гэсэн 3 бүсэд хуваагдана. Онгон бүс нийт нутаг дэвсгэрийн 17.3 % буюу 7115.3 га, хамгаалалтын бүс 54.2 % буюу 22291.9 га хязгаарлалтын бүс 28.5% 11721.8 га талбайг тус тус эзэлдэг байна.

Богдхан Уулын ам хөндий хажуу хормойгоор бичигт зурагт хад цохионууд, хиргисүүр, хөшөө булш зэрэг түүхийн дурсгалт зүйл олонтой. Цэцээ гүний орой дээр сайд


Юндэндоржид зориулсан сүмийн туурь байдаг. Их, Бага тэнгэрийн аманд орших хадан цохион дээр согоо, гуа марал, бортого малгай, ээтэн гутал, нөмгөн дээлтэй бүсгүй хүний дүрс, бугын сүг зураг зэргийн хамт уйгаржин бичгээр сийлсэн “Мөнх тэнгэрийн хүчин суу залийн ивээлд” гэсэн дурсгалын бичиг байдаг.

**Түүх, соёлын өв:** Богдхан уулын Дархан цаазат газрын нутаг дэвсгэрт байгалийн өвөрмөц тогтоцтой, түүх дурсгалын газрууд олон бий. Үүнд: Цэцээ гүний оргил, Төрхурахын ам, Шажинхурахын ам, Залаат, Шавартын ам, Манзуршир хийд, Нүхтийн ам, Зайсан толгой зэрэг түүх соёлын дурсгалыг хадгалсан бүсэд 300 гаруй аж ахуйн нэгж, байгууллага аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байна. Богдхан уулын дархан цаазат газрын Түүх соёл үл хөдлөх дурсгалт зүйлийг тэмдэгжүүлэхэд нийт 197 дурсгал бүртгэгдсэн байна.

## 2.6 Тусгай хамгаалалттай газар нутаг

Богдхан уулын Дархан цаазат газар нь нийслэл хотын дэргэд байрладаг, дэд бүтэц илүү сайн хөгжсөн, байгалийн иж бүрдлийг төлөөлсөн үзэсгэлэн төгөлдөр олон амуудтайгаас гадна хадны сүг зураг, Мэргэн Тоньюкийн хөшөө сүм, хийдийн суурь, туурь зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд олонтой юм.

Цармын ой хээрийн болон нугын хэв шинжит хамаарах уррамлын нөмрөгтэй бөгөөд нийт талбай нь 55,8% буюу 22,9 мянган га газрыг ой мод эзэлнэ. Үүнээс шинэс 56,8%, хуш 22,2%, гацуур 15,4%, нарс 1,4%, хус 2,6%, бут сөөг 1 хувийг тус тус эзэлнэ.



Зураг 8. Богдхан уулын ДЦГ-ын ойн сан

Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээр, хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг. Дархан цаазат уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс дээш 2268.0 м өндөрт өргөгдсөн Цэцээ гүн юм.

## **2.7 Нийгэм эдийн засаг**

### **Баянзүрх дүүргийн онцлог**

Баянзүрх Дүүрэг нь 26 хороонд хуваагддаг. Баянзүрх дүүрэг 124.4 мянган га газар нутагтай, Богд хан уулын Бага тэнгэр, Богино Хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төр хурахын ам, Хар усан тохой зэрэг ан амьтан, цэцэг жимс, ой мод, рашаан ус, эмийн ургамал бүхий үзэсгэлэнт сайхан байгальтай юм.

Гоёмсог барилга, өргөн гудамж, зам талбай, гүүр, хөшөө дурсгал бүхий хотын шинжийг агууласны сацуу уул толгод, ой хөвч, тал хээрийг багтаасан үзэсгэлэнт байгаль бүхий Нийслэл хотын хамгийн том дүүрэг юм.

### **Баянзүрх дүүргийн газар нутаг**

Тус дүүрэг 124410 га нутаг дэвсгэртэй бөгөөд үүний 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67.6 хувь буюу 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11.3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт харьяалагддаг.

### **Баянзүрх дүүргийн засаг захиргаа**

Баянзүрх дүүрэг нь засаг захиргааны бүтцийн хувьд төрийн удирдлагыг өөрөө удирдах ёсны удирдлагатай хослуулан барих хуулиар олгогдсон бүрэн эрх бүхий дүүргийн Засаг даргатай юм. Мөн анхан шатны 26 хороотой, дүүргийн төр захиргааны 30 гаруй хэлтэс, албатай бөгөөд иргэдээс сонгогдсон 35 төлөөлөгч бүхий Иргэдийн төлөөлөгчдийн хурал гэсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон ажиллаж байна.

Дүүргийн хэмжээнд 59189 өрхтэй, 380 мянган хүн амтай, 28 хороонд 8,000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 24 мянган өндөр настан амьдарч байна. Мөн дүүргийн хэмжээнд 4700 гаруй аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс 151 нь төсвийн, 420 нь төрийн бус байгууллага бол 18 нь хувьцаат компани, 3345 нь ХХК юм. Мөн төрийн өмчит үйлдвэрийн газар 49, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 13 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг. Одоогийн байдлаар 42686 толгой мал, 274887 тахиа, шувуу зэрэг эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, дэд бүтэц, зам тээвэр хөгжсөн, Төрийн өмчийн 19 дунд сургууль, 25 цэцэрлэг, 21 дээд болон их сургууль, коллежтэй, эрүүл мэнд, урлаг, соёл, спорт хөгжсөн дүүрэг юм.

### **Эдийн засгийн хөгжил**

Баянзүрх дүүргийнхэн нийслэлийн хэмжээний аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн 21 хувь, нийт борлуулалтын 20,7 хувийг цаашлаад Монгол Улсын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлтийн 7.5 хувь, нийт борлуулалтын 9,2 хувийг үйлдвэрлэн борлуулж байна. Дүүргийн хэмжээгээр аж үйлдвэрийн жилийн дундаж үйлдвэрлэлт 272.8 тэрбум төгрөг, борлуулалт 286.7 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

### **Боловсрол, соёл шинжлэх ухаан**

Төрийн өмчийн 23 цэцэрлэг, Төрийн бус өмчийн 63 цэцэрлэгт нийтдээ 11705 гаруй хүүхдүүд суралцан 350 гаруй багш сурган хүмүүжүүлж байна. ЕБ-н Төрийн өмчийн 17 сургууль, Төрийн бус өмчийн 10 сургууль нийтдээ 22333 сурагч бага дунд суурь бүрэн дунд боловсролыг эзэмшиж байгаа бөгөөд 1500-аад багш ажиллаж байна. Дүүрэгт орших улсын, хувийн нийт 21 их дээд сургууль коллежид 19.800 оюутан суралцаж, 955 багш ажиллаж байна.

### **Эрүүл мэнд**

Баянзүрх дүүрэгт ЭМН-1, Нэгдсэн эмнэлэг 1, өрхийн эмнэлэг 26, хувийн хэвшлийн эмнэлэг 18, ЭМН-ийн харьяа амбулатори 1, эрүүл мэндийн 75 гаруй байгууллага иргэдэд нарийн мэргэжлийн болон суурь тусламж үйлчилгээг хүргэж байна.



Зураг 9. Улаанбаатар хотын газар ашиглалт

Төслийн барилгын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь оршин суугч иргэдийн тайван байдалд нөлөө үзүүлэх болно. Гүний усыг ашигласнаар усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих машин тэрэгний тоо нэмэгдсэнээр олон салаа зам гарч хөрсний эвдрэл өнгөн давхаргад нөлөөлж болзошгүй.

Оршин суугч иргэдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тээврийн машинуудад дуу чимээний холбогдох стандартуудыг дагаж мөрдөх шаардлагыг тавьж, хэрэгжүүлэх, үйл ажиллагааны тоосжилтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, иргэдийг ажлын байраар хангах, байгаль орчноо хамгаалах сургалт явуулах зэрэг ажлуудад иргэдийг хамрагдах боломж олгох мөн голын болон худгийн усанд тогтмол хяналт шинжилгээ хийх зэрэг болно.



## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

*Хүснэгт 7. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа*

Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Сөрөг Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
<b>Нэг. Төслийн үйл ажиллагааны явцад</b>				
Шатах тослох материал, ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал голын ус болон хөрсөнд шингэх	Гүний ус, голын ус, газрын хөрс, ургамал, амьтан, ус, агаар	Төслийн талбай, туул голын ус	Бага	Төсөл хэрэгжих хугацаанд
Усны нөөц хомсдох	Гүний ус	Төслийн талбай (нөөц хомсдох)	Их	Төсөл хэрэгжих хугацаанд
Ойн Түймэр	Хүн, мал, эд хогшил, ургамал, ой, хөрс	Төслийн талбай эргэн тойронд	Дунд	Тогтоох боломжгүй
Зам, жим харгуй ихсэх	Агаар, хөрс, хүн, амьтан, ургамал	Авто зам түүний ойр орчим	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд
<b>Хоёр. Бүтээн байгуулалтын явцад</b>				
Ногоон байгууламж байгуулах	Газрын хөрс, амьтан	Төслийн талбай	Дунд	Төсөл хэрэгжих хугацаанд
Цементэлсэн ил зогсоол байгуулах	Геологийн тогтоц, газрын хөрс, ургамал, амьтан, агаар	Төслийн талбай	Их	Төсөл хэрэгжих хугацаанд

*Хүснэгт 8. Гол нөлөөллийн дүн шинжилгээ*

Нөлөөллийн ангилал	Гол нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн үргэлжлэх хугацаа
<p>1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулах</li> <li>• Эвдэх</li> <li>• Доройтуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Санамсаргүй алдаа гарсан тохиодолд автомашины тос алдаж хөрс, шороо бохирддог.</li> <li>• Хөрс эвдэх нөлөөлөлд амрагчид газрын хөрсийг дураараа сэндийчих, барилга өргөгтөн барих ажлууд хамаарагдаж байна.</li> <li>• Доройтуулах нөлөөлөлд автомашины хүн тээврийн маршрут, хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашаалаагүй зэрэг хамаарагдаж байна.</li> </ul>	<p>Төслийн эдэлбэр газрын хэмжээ (8500 м<sup>2</sup>)</p>	<p>Хөрс бохирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.</p> <p>Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.</p> <p>Хөрс доройтуулах нөлөөллийн эрчим дунд зэрэг эрчимтэй байна.</p>	<p>Төсөл хэрэгжих хугацаанд</p>
<p>2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулах</li> <li>• Нөөцийг бууруулах</li> </ul>	<p>Үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл нь ШТМ асгарах, бохирын шугам алдах зэрэг орно.</p> <p>Газрын гүний ус ашигладаг учраас</p>		<p>Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн эрчим их байна.</p>	<p>Төсөл хэрэгжих хугацаанд</p>

	нөөцөд бага зэрэг нөлөөлнө.			
3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл <ul style="list-style-type: none"> <li>• Амьдрах орчинг хуваах</li> <li>• Амьдрах орчинг доройтуулах</li> <li>• Амьдрах орчинг хомсдуулах</li> <li>• Нөөцийг бууруулах</li> </ul>	Амрагчдын хөл хөдөлгөөн, чөлөөт аялал, барилга өргөтгөх, хашаалах ажлууд нь тэдгээрийн амьдрах орчныг хуваах, доройтуулах, хомсдуулах нөлөөллийг үзүүлж байна.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ (8500 км <sup>2</sup> )	Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
4. Агаарт үзүүлэх нөлөөлөл <ul style="list-style-type: none"> <li>• Бохирдуулах</li> <li>• Тоос</li> </ul>	Галлагааны зуухаас угаар, автомашины шатаасан хийн угаар нь агаарыг бохирдуулж түүний чанарыг доройтуулдаг.  Замын барилгын ажил нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ (8500 км <sup>2</sup> )	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс <ul style="list-style-type: none"> <li>• Хамгаалах</li> <li>• Нүүлгэн шилжүүлэх</li> </ul>	-	-	-	-

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь үйлчлүүлэгчдийн хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холхиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг

алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

### **3.1 Төслийн барилга байгууламжийг өргөтгөн барьж байгуулах үеийн гол нөлөөлөл**

- Барилгын материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, барилгыг барих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Будаг, маажин, цавуу мэтийн химийн бодис асгарснаас хөрс ургамал, хөрсний ус, голын ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах
- Төслийн талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд орно.

### **3.2 Барилга байгууламжийг өргөтгөн барьж ашиглалтад оруулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл**

- Объектын орчин тойронд хөрс, ургамал нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор голын эрэг бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, явган хүний жим зам тавих, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай. Барилга байгууламж барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, голын ус болон эрэг бохирдох, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

Эдгээр сөрөг нөлөөлөл нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй хандсанаас үүсч болно. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах бүлэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл



хэрэгжүүлэгч цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

### **3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Төсөл хэрэгжих орчимд агаарын бохирдол харьцангуй бага байна гэж үзэж байна. Энэ нутгийн агаар, ус, хөрс, ургамал байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан бөгөөд ялангуяа уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшилын бүсээс зайтай, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр байхгүй учир тухайн төсөл хэрэгжих талбайн агаар нь харьцангуй цэвэр ба төслийн үйл ажиллагаанаас суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна.

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

Цаашид цогцолбор ашиглалтанд орж үйлчилгээний явцад амрагч жуулчдын ирж очих машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэрийг доор дурдсан байдлаар ялган төсөөлж болох юм. Үүнд:

↳ Ургамалын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах

↳ Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Иймд төсөл хэрэгжих орчин нь Богдхан уулын ДЦГазар гэдгийг харгалзан үзэж хүний үйл ажилагаанаас үүдэлтэй тоосны сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам, хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох нь нэн чухал юм.

Тээвэрлэлтийн /Барилгажилтын/ үед эвдэрсэн газрыг тухай бүр нөхөн сэргээх, аль болохоор олон салаа зам гаргахгүй байх, амрагч жуулчид ирж очих гол замыг цаашдаа хатуу хучилттай болгох зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

### **Хийн хаягдлаас үүсэх гол сөрөг нөлөөлөл**

Автомашин утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулна. 1кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин  $q=0.725$ , дизель  $q=0.825$ ) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашин утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо бензин хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агууламжийг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агууламжийг үндсэн үзүүлэлт болгодог.

*Хүснэгт 9. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ*

Бохирдол	Автомашин асаалттай, сул	Машин хурдтай явж байх үед	Машин тойргоор эргэх үед	Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош )
----------	--------------------------	----------------------------	--------------------------	---

	<b>зогсолттой байх үед</b>	<b>(60 км/цагаас дээш)</b>		
<b>СО (%)</b>	4 – 9	< 1 – 8	1 – 7	2 – 9
<b>НС, С<sub>6</sub>Н<sub>14</sub> (ppm)</b>	500 – 1000	50 – 80	200 – 800	3000 – 12 000
<b>NO<sub>x</sub> (ppm)</b>	10 – 50	1000 - 4000	1000- 3000	5 – 50

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулав. Энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингийн хяналтын үзүүлэлт, ашиглагдах ач холбогдол юм.

*Хүснэгт 10. Автомашины утааны бүрдэл найрлага*

№	Бүрдэл	Хөдөлгүүрийн төрөл		Тайлбар
		Бензин	Дизель	
1	Азот (%)	74-77	76-78	<b>Хоргүй</b>
2	Хүчилтөрөгч (%)	0.3-8	2-18	<b>Хоргүй</b>
3	Усны уур (%)	3-5.5	0.5-4	<b>Хоргүй</b>
4	Нүүрсхүчлийн хий (%)	5-12	1-10	<b>Хоргүй</b>
5	Нүүрстөрөгчийн исэл (%)	1-10	0.01-0.5	<b>Хортой</b>
6	Азотын исэл (%)	0.1-0.5	0.001-0.4	<b>Хортой</b>
7	Альдегид (%)	0.0-0.2	0-0.009	<b>Хортой</b>
8	Нүүрс-устөрөгчид (%)	0.01-0.02	0.01-0.5	<b>Хортой</b>
9	Хүхэрлэг хий (%)	0-0.002	0-0.03	<b>Хортой</b>
10	Хөө тортог (г/м <sup>3</sup> )	0-0.44	0.01-1.1	<b>Хортой</b>
11	Бенз (а) пирен (г/м <sup>3</sup> )	<0.00002	<0.00001	Хортой

Хүснэгтээс харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн хэмжээ нь 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

### **3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл**

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлийн бага зэрэг эвдрэлтэй, ихэнх хэсэг харьцангуй унаган төрхөө хадгалсан, хэсэг газар ургамал хөрс талхлагдаж, ухмал нүх үүссэн, одоогийн байдлаар бага зэрэг хог хаягдалтай байна.

Тус төсөл хэрэгжихэд нийт талбайн 16% буюу 1.0 га талбайн гадаргуу өртөгдөж байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.

#### **🚧 Төслийн өргөтгөл барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Барилга барих явцад барилгын суурь ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элсжилт үүсэх
- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр газрын гадарга, хэвлий бохирдох
- Болзошгүй тохиолдлоор гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

### **3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл**

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газар нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс-биолог амьсгалын Хангайн мужийн өндрийн бүсшил бүхий Хангай-Хэнтийн өмнөдийн хэв шинж бүхий 52 дугаар тойрогт хамрагдана. Энд уулын бэлээр нугын, уулын хойд хажуугаар уулын ширэгт-тайгын, уулын хар шороон, уулын ойн бараан, уулын хар шороон, уулын хар хүрэн хөрснүүд тус тус тархана.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

#### **Төслийн өргөтгөл барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- Барилгын суурь ухах, цугтах зэрэг үйл ажиллагаанд газрын хөрс бохирдох
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

#### **Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төслийн барилга байгууламжийн үйл ажиллагаа явагдах үед нийт талбайн 16% буюу 1.0 га талбайн хөрс ургамал эвдрэлд орно.
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Амрагч жуулчдын тоо олширч түүнийгээ даган тээврийн хэрэгсэл ихэссэнээр зам жим олширч элэгдэл ихсэх, эрэг мөргөцөг нурах, эвдрэх гэх мэт болно.

### **3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл**

Төслийн талбай болон түүний орчмын газар нутаг нь Монгол орны байгалийн мужлалаар ойт хээрийн бүсэд багтана.

Уулын ойт хээрт хамаарах ихэнх нутагт жилдээ 300-400 мм, Хангай, Хэнтий, Монгол-Алтайн нурууны захын салбар уулсаар жилдээ 200-300 мм тунадас унадаг, ургамал ургах хугацааны хувьд тогтмол дулаарсан (+5<sup>0</sup>C-ээс дээш) 132-150 (145) хоног үргэлжилдэг юм. Гэвч уулсаараа ургамал ургах хугацаанд зожир хүйтрэлтэй байдаг. Сүүлчийн цочир хүйтрэлт ихэнхдээ 6-р сарын дундуур, эхний цочир хүйтрэлт 8-р сарын дундуур ажиглагдана. Цаг уурын олон жилийн дунджаас үзэхэд ихэнхдээ хавар, намартаа түр зуурын гандуу үе илэрнэ.

Барилга байгууламж барих болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр /Амрагч жуулчдын хөл хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

#### **Төслийн үйл ажиллагаанаас ургамлан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,
- Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- Төсөл орчмын мод бут механик гэмтэлд өртөх

#### **3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл**

Төслийн талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Хэнтийн тайгын голлох элемент болох олон зүйлийн хөхтөн амьтдын тархалттай. Хан Хэнтийн дархлагдсан нутгийн хүрээнд 15 овог, 27 төрөлд хамаарах 50 гаруй хөхтөн, суурин болон нүүдлийн 250 гаруй зүйлийн жигүүртэн шувуу, 3 зүйл могой, 1 зүйл бах, 1 зүйл гүрвэл болон 9 зүйл загас тэмдэглэгдсэн байдаг боловч сүүлийн жилүүдийн аялал жуулчлалын бааз, цогцолборуудын суурьшил, Богдхан уулын ДЦГ-ын аялал зугаалга зэргээс ан амьтан үргэн дайжсан байдалтай байна. Зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу, бичил биетэн зэрэг амьтад байгаа болно. Энэ нь Улаанбаатар хотын ойр орчмын хүн амын нягтшил, аж ахуйн хөгжил, замын хөдөлгөөнтэй холбоотой.

#### **Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устах, хордох
- Төслийн барилгын ажлын үе болон хэрэгжүүлэх хугацаанд амрагчдын тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

#### **3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл**

Төслийн талбай нь Богдхан уулын ДЦГ-ын тусгай хамгаалалттай газар дахь Хүрэлтогоотын амны хөндийд байгаа мөн намаг, сайр дагаж тогтсон түр урсгалтай горхи, нарийн жалга дагаж хур борооны үед богино хугацаанд үүсдэг түр ширүүн урсгалтай хурын үер зэргээс тогтож байна.

Гадаргын болон гүний усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд, бичил бохир цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усыг тоосжилт болон ногоон байгууламжийн усалгаа зэрэгт эргүүлэн ашиглах, үер болохоос сэргийлж далан байгуулах, голын ойр орчимд ахуйн болон үйлдвэрийн бохирдлоос сэргийлэх хамгаалалтын төлөвлөгөө, анхааруулга сэрэмжлүүлэг бүхий самбар, мөн гүний ус ашиглалтыг хянах, хэрэглээг багасгах, гүний усны цооног болон гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг багтана.

#### **Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар дамжуулан гол горхи бохирдуулах



- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын гол горхины ус ба түүний эргийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Туул голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдах


Сүүлийн жилүүдэд Туул голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдаж хавар, намрын улирлын урсацын хэмжээ багасах, үргэлжлэх хугацаа ихсэх, харин үерийн хэмжээ ихсэх, үргэлжлэх хугацаа багасах зэргээр өөрчлөгдөж, урсацын хуваарилалт орон зай ба цаг хугацааны хувьд алдагдсан байна. Ус ашиглалтын хэмжээ, хэрэгцээ нэмэгдэж, ашиглалтын горим нь голын горимтой зөрчилдөж байгаа шалтгаанаар улирлын чанартай хомсдол бий болдог байна.

### **3.9 Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл**

Богдхан уулын Дархан цаазат газар нь нийслэл хотын дэргэд байрладаг, дэд бүтэц илүү сайн хөгжсөн, байгалийн иж бүрдлийг төлөөлсөн үзэсгэлэн төгөлдөр олон амуудтайгаас гадна хадны сүг зураг, Мэргэн Тоньюкийн хөшөө сүм, хийдийн суурь, туурь зэрэг түүх, соёлын дурсгалт газрууд олонтой юм. Энэ байдал нь эх орны төдийгүй гадаадын зочид гийчид, аялагч жуулчдын сонирхлыг их хэмжээгээр татаж байдаг учир Богдхан уул нь аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой бүс нутгийн тоонд зүй ёсоор ордог.

Дархан цаазат Богдхан уулыг анх 12-13 дугаар зууны үед Монголын Хэрэйд аймгийн тэргүүн Ван хаан өөрийнхөө эрх хэмжээгээр дархалсан бөгөөд дараа нь 1778 онд Хүрээ Ван сайд Юндэндорж Манжийн хаанд бичиг өргөн барьж албан ёсоор дархлан хамгаалсан нь манай орны төдийгүй дэлхийн ууган дархан газрын нэг болсон юм. Их хотын дэргэд орших эртний түүх, соёлын дурсгалт энэ уулыг 1957 онд УИХ-ын Тэргүүлэгчдийн 31 дүгээр тогтоолоор Чойбалсан уул нэрээр дархалж, 1974 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн 248-р зарлигаар хуучин нэрийг эргүүлэн Богд уул нэрээр 41651 га талбайг хамруулан дархан цаазат болгожээ. Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолоор дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулжээ.

Цармын ой хээрийн болон нугын хэв шинжит хамаарах уррамлын нөмрөгтэй бөгөөд нийт талбай нь 55,8% буюу 22,9 мянган га газрыг ой мод эзлэнэ. Үүнээс шинэс 56,8%, хуш 22,2%, гацуур 15,4%, нарс 1,4%, хус 2,6%, бут сөөг 1 хувийг тус тус эзлэнэ.



Зураг 10. Богдхан уулын ДЦГ-ын ойн сан

Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээр, хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг. Дархан цаазат уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс дээш 2268.0 м өндөрт өргөгдсөн Цэцээ гүн юм.

Богдхан уулын Дархан цаазат газарт аялал жуулчлал явуулах зам чиглэлийг танин мэдэхүйн болон экологийн хүмүүжил олгох ач холбогдол, зан үйлийн эрт, эдүгээгийн ёс заншил, уламжлалыг харгалзан Ар Зайсан-Зүүн ширээт уул-Их ёл-Бага ёл-Түшээ гүн уул-Цэцээ гүн оргил-Манзуширын хийд-Төрхурах-Цэцээ гүн, Зайсан-Цэцээ гүн-Одон орон судлах төв зэрэг чиглэлээр тогтоосон байна.

**Чандманы ам:** Хийморийн овоо буюу эрчүүдийн овоо: Энэ овоонд гарч монголчууд хийморь лундаагаа сэргээхээр билгийн тооллын сайн өдөр гарч хийморийн дарцаг хийсгэж арц хүчээр арвилан тахидаг.

**Цэцээ гүн:** Богдхан уулын дархан цаазат газрын ноён оргил бөгөөд Монголын төрийн тахилгат дөрвөн уулын нэг юм. Цэцээ гүний оргилд Хангарьд шувуу хэлбэртэй хад байдаг. Энэ оргилыг 4 жилд нэг удаа ерөнхийлөгчийн зарлигаар тахидаг.

Богдхан ууланд эмчилгээний ач холбогдолтой хэд хэдэн рашаан булгууд бий. Зарим газар хушин ой, баруун урд ба өмнөд хэсгээр гацууран ой, баруун урд хэсгээр нарсан ой, хойд ба зүүн өмнөд хэсгээр нь шинэсэн ой зонхилон тархдаг нь тус уулын хэсэг бүрт экологийн нөхцөл өөр байдгийг гэрчилнэ. Богдхан ууланд 70 овгийн 256 төрлийн 588 зүйлийн дээд ургамал ургадаг. Ургамлын аймаг нь экологийн 18 бүлэгт хамаарах бөгөөд эдгээрээс уулын тайгын экологийн бүлгүүд 80 хувийг, хээрийн ургамлууд 72 хувийг эзэлдэг. Хэнтийн тайгын голлох элемент болон олон зүйлийн хөхтөн амьтны тархалтын урд



хил нь Богдхан уул болно. Богдхан ууланд монгол орны 6 баг, 17 овог, 36 төрөл, 54 зүйлд хамаарах хөхтөн амьтан нутагладаг байна. 174 овог, 270 гаруй төрөлд хамаарах 1660 зүйл шавж, 259 зүйлийн мезофаун, 93 микрофаун, 14 баг, 36 овогт багтах 194 зүйл шувуу бүртгэгдсэн байна.

**Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх болзошгүй нөлөөлөл, үнэлгээ**

Тус төслийг ДЦГ-ын хягаарлалтын бүсийн дэглэм, аюулгүй ажиллагаа, холбогдох хуулийн дагуу, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлсэн тохиодолд сөрөг нөлөөлөл нь харьцангуй бага байх боломжтой.



**Хязгаарлалтын бүс:** - Хязгаарлалтын бүсэд явуулах арга хэмжээ, үйл ажиллагааг ТХГН-ийн тухай хуулинд доорх байдлаар тодорхойлсон байна.

1. Байгалийн унаган төрхийг хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд нөлөөгүй арга хэлбэрээр шинжилгээний ажил явуулах, ургамал амьтан өсч үржих нөхцлийг хангах, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авна.
2. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй хэлбэрээр зохих зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулна
3. Уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх
4. Зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийн баталгаажсан зураг төслөөр, холбогдох хууль дүрмийн дагуу үйлчилгээний байгууламж барих
5. Баталгаажсан зураг төсөл журмын дагуу зам зогсоол хийх
6. Биеийн тамир, нийтийн арга хэмжээнд зориулсан талбай засах тохижуулах

Аялал жуулчлалын бааз төсөл нь Улаанбаатар хот Хан-уул дүүргийн Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд хэрэгжиж байгаа. Тус төслийг ДЦГ-ын хязгаарлалтын бүсийн дэглэм, аюулгүй ажиллагаа, холбогдох хуулийн дагуу, байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлсэн тохиодолд сөрөг нөлөөлөл нь харьцангуй бага байх боломжтой.

*Хүснэгт 11. Тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх сөрөг нөлөөлөл*

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөлөл байхгүй	Нөлөөллийн эрчим		
			Бага	Дунд	Их
1	Тусгай хамгаалалттай бүс нутгийн ховор, ховордсон биологийн төрөл зүйлийн амьдрах орчинд нөлөөлөл	0			
2	Түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүргэх	0			
3	Ой модыг огтлох, гэмтээх	-			
4	Булаг шандны усны горимд өөрчлөлт орох ба хатаж ширгэх аюултай эсэх	0			
5	Голын гольдирол эвдэж өөрчлөх эсэх	-			
6	Төслийн үйл ажиллагаанд сонгосон техник, тоног төхөөрөмжийн шийдэл, түүхий эд нь байгаль орчинд хэр нийцтэй эсэх	+	+		
7	Барилга байгууламж барих хөрсний эвдрэл	-			-
8	Барилга байгууламж баригдаж дууссаны дараах хөрсний эвдрэл	-		-	
9	Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс, ургамал талхлагдах эсэх	-	-		
10	Үйчлүүлэгчдийн тоо ихэссэнээр автомашин олширч агаарын бохирдол үүсгэх эсэх	-		-	
11	Хог хаягдлыг ил задгай хаяснаас орчны бохирдол үүсгэх	-	-		
12	<b>Төслийн байгууламж хооронд хөрсний бохирдол үүсэх эсэх</b>	-	-		

Тайлбар: (0) нөлөөлөлгүй

(-) сөрөг нөлөөлөлтэй

(+) эерэг нөлөөлөлтэй

-	6	50 %
+	1	8.3 %
0	3	41.7%

Дээрх нөлөөллийн үнэлгээнээс тооцож үзвэл энэ төсөл тусгай хамгаалалттай бүсэд нөлөөлөл байдлаараа “бага” нөлөөлөлтэй ангилалд багтаж байна.



Төслийг хэрэгжүүлэх явцад хөрсөн бүрхэвчид хамгийн ихээр нөлөөлнө. Мөн барилга байгууламж барих үед гадаргын төрх өөрчлөгдөж, ургамлан нөмрөг талхлагдах, үйлчлүүлэгчдийн тоо ихэссэнээр автомашины тоо олширч агаарт хийн хаягдал үүсгэх, хог хаягдлыг ил задгай хаяснаар орчны бохирдол үүсгэх сөрөг нөлөөтэй.

Нөлөөллийг бууруулахын тулд төслийн барилга байгууламж хооронд явган хүний зам гаргах, машины зогсоолыг хатуу хучилттай хийх, хогийн сав болон хог хаягдлыг түр хадгалах цэгтэй байх, тухай бүрт нь ачуулах шаардлагатай.

### **3.10 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл**

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт багагүй орлого оруулах, зуны улиралд ажлын цөөнгүй байр гардаг нь ажилгүйдлийг багасгах, хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх чухал хүчин зүйл болж байна. Ийнхүү байгалийн үзэсгэлэнт нөхцөл бүрдсэн энэ нутагт амралт сувилалын газар ихээхэн хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлж буй боловч тухайн орон нутгийн экологийн чадавхаас хэтэрсэн ажил үйлчилгээ эрхлэх хэт олон том жижиг цогцолбор, бааз байгуулж хүн амын төвлөрөл бий болгох хөл хөдөлгөөн ихэсгэхээс аль болохоор зайлсхийх, тусгай хамгаалалтын бүс нутгийн дүрэм журмын дагуу зохих хязгаарлалт хийх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд нэгэнт байгуулагдсан болон байгуулах гэж буй амралтын газрууд нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамгийн бага хэмжээнд хүртэл нь бууруулах талаар туйлын хариуцлагатай хандаж идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Төслийн барилгын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо оршин суугч иргэдэд нөлөөлөл үзүүлэх болно. Оршин суугч иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

### **3.11 Хуримтлагдах нөлөөлөл**

“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн Буудаллах, отоглох, орон байр байгуулах төсөл нь Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд хэрэгжиж байгаа бөгөөд тухайн бүс нутагт аялал жуулчлалын амралтын газруудын үйл ажиллагаа явагддаг ба төслүүдийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол, хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нөмрөг доройтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-г цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлагнах нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад баригдах барилга байгууламжийг барьж байгуулах, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа болон ТХГН, орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

*Хүснэгт 12. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл*

<b>№</b>	<b>Хуримтлагдах нөлөөлөл</b>	<b>Нөлөөллийн шалтгаан</b>	<b>Хамрах цар хүрээ</b>	<b>Үргэлжлэх хугацаа</b>
<b>1</b>	Газрын гадарга ба хэвлий эвдрэлд өртөх	Бусад төслүүдийн нөлөөлөл	Төслийн талбай, нөлөөллийн бүс, ТХГН-ын хязгаарлалтын бүс	Өнгөрсөн, одоо, ирээдүй
<b>2</b>	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал		Одоо, ирээдүй
<b>3</b>	Гадаргын ус бохирдох болон эргийн эвдрэлд өртөх	Бусад төслүүдийн нөлөөлөл		Өнгөрсөн, одоо, ирээдүй
<b>4</b>	Ургамал ой модны нөмрөгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа		Өнгөрсөн, одоо, ирээдүй
<b>5</b>	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт, бусад төслүүдийн ба хотын бохирдлын давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй
<b>6</b>	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй
<b>7</b>	Амьтан дайжих, тоо толгой цөөрөх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

“Блэк энд вайт дрийм” ХХК нь Буудаллах, отоглох, орон байр байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар 09	Сар 10	Сар 11		
	1	2	3	4	5	6	7
1.	Ногоон байгууламж байгуулах	900.0	захиалга	хүлээлцэх		Гүйцэтгэх захирал	
	Нийт	900.0					

### ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн “Буудаллах, отоглох, орон байр” байгуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

Хүснэгт 13. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар орчин	Барилга байгууламж байгуулах үеийн газар шорооны ажлаас тоосжилт үүсэх	Төслийн барилгажилтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх, салхи ихтэй, хуурайшилттай үед хучиж бүтээх зэргээр тоос багасгах арга хэмжээ авах	Төслийн талбайн авто зогсоол, хаягдал бохирын цооног	1	--*--	1	1600.0	Төслийн бүх үе шатанд	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 /ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт – Ус



*“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дахь Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах “Буудаллах, отоглох, орон байр” байгуулах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

										<i>ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/</i>
3	Усны нөөц, чанар	Газрын доорх усыг авч ашигласанаар газрын доорх урсацын горим алдагдах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтад сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн Бохир ус дамжуулах шугам хоолойг зориулалтын бус материалаар хийх, шугам хоолойд гэмтэл үүсэх	Ус ашиглалтын гэрээг дүүргийн ЗДТГ болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах		1		1	--*--	Төсөл хэрэгжих хугацаанд	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586-98 (СХЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол.), Усан орчны чанарын хяналт шинжилгээ MNS4047-88 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал), Усны чанар, хаягдал бохир ус. MNS 4943-2014 Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
			Төсөл хэрэгжих эзэмшил болон хариуцан хамгаалах талбайг хаврын шар усны үерийн болон гадаргын усны урсацаас хамгаалах зорилгоор шуудуй байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	Талбайг тойруулан	1	200.0	1	200.0	Төслийн эхэн болон жил бүр	
			Худгийн эргэн тойрон хамгаалалтын						--*--	2024 онд

*“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дахь Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах “Буудаллах, отоглох, орон байр” байгуулах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

		зэргээс гүний усыг бохирдуулж болзошгүй.	бүс тогтоох, сэргээн засварлах							Усны тухай хууль ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт – Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
			Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах					--*--	Төслийн эхэнд болон жил бүр	
			ТХГН-ийн захиргаатай байгуулсан газар ашиглалтын гэрээний дагуу газрын төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Газрын талбайн хэмжээнээс хамаарч	4		4		--*--	Жил бүр

*“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дахь Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах “Буудаллах, отоглох, орон байр” байгуулах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

5	<b>Ургамал, амьтны аймаг</b>	Ургамал нөмрөг хүн, мал, техникийн нөлөөгөөр устах, сийрэгжих, улмаар энэ нь ургамал нөмрөг их хэмжээгээр алдралд орох эх үүсвэр болж болно. Хөхтөн, шувууд зэрэг амьтдыг дуу чимээ, гэрэл, машин техникийн ажиллагаа зэрэг газар шорооны үйл ажиллагааны улмаас үргээж, дүрвээх ба айлган цочоож болзошгүй.	Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх, замын нэгдсэн сүлжээг гаргах	Төслийн талбай	1	2	200.0	200.0 х жилд 2 удаа = <b>400.0</b>	Төсөл хэрэгжих үед байнга Төслийн эхэн үед
		<b>Нөлөөллийг бууруулах нийт зардал</b>							<b>2230.0</b>

### ЗУРГАА.ОРЧНЫ ТОХИЖИЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Төслийн талбайд мод тарих (Тайлбар: “Улаанбаатар хотын 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц, суулгацын ААНБ-ын судалгаа” “Тоонот байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)	Төслийн талбайд <i>Эхний жил</i>	ширхэг	35	66,000	35ш x 230,000Т = <b>2310.0</b>	Жил бүр	
	Нийт						2310.0		

### ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний нөлөөлийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олоход үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.



### НАЙМ.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.	Ахуйн	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх	Хог хаягдлын цэг	-	200.0	3	600.0	2024 оны дунд	Хог хаягдлын тухай шинэчилсэн хууль 2017.05.12
2.	Үйлдвэрийн	Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулах, Байр сууц бүрт орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх		-					
3.	Аюултай	Нэг удаагийн хэрэглээний зүйлээс татгалзаж, дахин ашиглагдах материалаар хийсэн эд зүйлс хэрэглэх		-	140.0	1 удаа	140.0	2024 оны дунд, сүүлд	
	<b>Нийт</b>						<b>740.0</b>		

### ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (урьдчилсан мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	Агаарын чанар:  Агаарын тоосны (TSP, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх  Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар.	Төслийн талбайн авто зогсоол	Тоосны хяналт: Төслийн талбайд 1цэгт жилд 1 удаа  Агаарын найрлага: жилд 1 удаа	Шинжилгээний зардал 1 удаагийнх 200.0 төгрөг зарцуулна.  Багажийн түрээсийн зардал: 1 багаж  Нийт 90.0 төг	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
2	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO <sub>3</sub> ), Ca, Mg, Na, K, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)  Усны түвшин (газрын гадаргаас доош, м-ээр)	Худаг: Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас  Унд ахуйн усыг хангаж буй гүний худагт	Жилд 1 удаа  Ус ашиглахаас өмнө нэг удаа, ус ашиглах явцад сар бүр, ашиглалт дууссаны дараа нэг удаа	200.0  --*--	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %,	Төслийн талбайн хог хаягдлын цэг эсвэл бохирын шугамын холболт хэсэг сонгох	Төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө 1 удаа,  Жилд 1 удаа	Нийт 1 цэгт х 3дээж х /15.0 + 25.0/ = 120.0 /Хөрсний химийн шинжилгээ 1дээж-15.0₮, хүнд металлын	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,

*“Блэк энд вайт дриим” ХХК-ийн Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дахь Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах “Буудаллах, отоглох, орон байр” байгуулах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

	<p>ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO<sub>3</sub>, P<sub>2</sub>O<sub>5</sub>, K<sub>2</sub>O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр</p>			<p>шинжилгээ 1дээж – 25.0₯/</p>	<p>MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,  MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,  MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга  MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага  MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга  MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга</p>
<p>Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тухайн жилийн нийт зардлын дүн</p>				<p>610.0</p>	

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар 9	Сар 10	Сар 11		
	1	2	3	4	5	6	7
1.	Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны дүгнэлт гаргуулах	--*--	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	Гүйцэтгэх захирал	
2.	Байгаль орчны аудит хийлгэх	1000.0	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	Гүйцэтгэх захирал	
	Нийт	1000.0					

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	2024 оны БОМТөлөвлөгөөг батлуулах	Цаасан	Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2024.08	-	Гүйцэтгэх захирал	БОАЖЯ
2.	2024 оны батлагдсан БОМТөлөвлөгөөг танилцуулан ажлыг эхлүүлэх	Цаасан	Ажлын жагсаалт, хугацаа, зорилтууд	2024.08	-	Гүйцэтгэх захирал	Төслийн талбай
3.	БОМТ-ны хэрэгжилтийн ажлын явцтай танилцах	Цаасан, зургаар	Хаягдал бохир усыг хөрсөнд үл нэвчих материалаар хийсэн байдал	2024.09	-	Гүйцэтгэх захирал	НБОГ
4.	БОМТ-ний дагуу хийгдсэн ажлыг хүлээлгэн өгөх	Цаасан, зургаар	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2024.11	-	Гүйцэтгэх захирал	НБОГ
5.	БОМТ-ны дагуу хийгдсэн ажлыг тайлагнах	Цаасан, зургаар	Тухайн онд хэрэгжүүлсэн	2024.12	-	Гүйцэтгэх захирал	НБОГ, БОАЖЯ



*“Блэк энд вайт дрийм”ХХК-ийн Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дахь Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах “Буудаллах, отоглох, орон байр” байгуулах төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

			байгаль орчны менежментийн төлөвлөгөө				
	Нийт				-		

**Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 6,960,000.0 төг**

**“БЛЭЖ ЭНД ВАЙТ ДРИЙМ”ХХК-ИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОРИУЛАЛТТАЙ  
ГАЗРЫН**

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН  
ХУУДАС**

<b>Хянасан огноо</b>	Шинжээч бөглөнө
<b>Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар</b>	Шинжээч бөглөнө
<b>Дүгнэлт</b> <ul style="list-style-type: none"><li>• Шийдвэрийн төсөл</li> <li>• Ололт, амжилттай тал</li> <li>• Дутагдалтай сул тал</li>  <li>• Шаардлага</li></ul>	Шинжээч бөглөнө


**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,  
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Блэк энд вайт дрийм” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9011650044
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Аялал жуулчлал, гадаад худалдаа
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	УБ, Хан-Уул, 11-р хороо, 3 хэсэг, энхжин хотхон, 32д, 23 тоот
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Г.Цогзол, 89088670, 75751712, sales1@abo.mn
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	Г.Гэрэлмаа, 88803643, gg.gerelmaa@gmail.com
1.2	1. Төслийн нэр	<i>Буудаллах, отоглох, орон байр байгуулах</i>
	2. Төслийн харьяаллын байршил	Баянзүрх дүүрэг дэх Богдхан уулын ДЦГазар Хүрэлтогоотын ам
	3. Төслийн ангилал	Аялал жуулчлалын цогцолбор
	4. Төсөл эхэлсэн огноо	2024 он
	5. Ажилчдын тоо	Нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.
	6. Тухайн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөө	Үйл ажиллагаагаа жигдрүүлж ажиллах
	7. Тухайн төсөлд хамрах дэд бүтэц <ul style="list-style-type: none"> <li>• замын урт, эхлэл, төгсгөлийн цэг, чиглэл;</li> <li>• хүчин чадал</li> </ul>	<p>Улаанбаатараас хот Баянзүрх дүүрэг ДЦГазар Хүрэлтогоотын ам засмал замаас 100м сайжруулсан шороон замтай.</p> <p>“Блэк энд вайт дрийм” ХХК-ийн буудаллах, отоглох, орон байр нь А загварын отоглох байр- 12 /1800м2/, В загварын отоглох байр-19 /2622м2/, С загварын отоглох байр-19 /1976м2/, Үйлчилгээний барилга-1 /1280м2/ нийт 51 барилга байгууламж баригдахаар төлөвлөсөн.</p> <p><b>Ажиллах хүч:</b> Нийт 27 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.</p>

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ,  
ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Газрын гэрчилгээний мэдээлэл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	2020 оны 05-р сарын 29-нд олгосон гэрчилгээ -0201605 -5 жил 60000м <sup>2</sup>
	2. Галын дүгнэлтийн огноо, дугаар Дугаар Хүчинтэй хугацаа	ашиглалтанд ороод авна. Одоогийн байдлаар үйл ажиллагааны барилгын бэлтгэл явагдаж байна.
	3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2023 оны 05-р сарын 11, 2022/ОА-70 Ц.Уранчимэг
	4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2024 он Ерөнхий шинжээч Ц.Уранчимэг Шинжээч О.Амарсанаа
	5. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо, 6. Хог хаягдлын гэрээний огноо, 7. Цахилгааны гэрээний огноо	ашиглалтанд ороод авна. Одоогийн байдлаар үйл ажиллагааны бэлтгэл явагдаж байна.
	8.ТХГН-ын тухай хууль, Хамгаалалтын захиргааны санал, хяналтын хуудас давхцсан эсэхийг тодорхойлсон лавлагааг хавсаргах	2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 1071 тоот санал

## ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1.	<p>1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>• Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/</li> <li>• Аюултай хог хаягдал</li> </ul>	<p>Хатуу хог хаягдал:</p> <p>Хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 113.7кг, жилд 41.5 тн орчим хаягдал гарах бөгөөд харьяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна. /Хавсралтаар хуурай хог хаягдлын гэрээг харуулав/</p> <p>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.</p> <ul style="list-style-type: none"> <li>✚ Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт</li> <li>✚ Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд</li> <li>✚ Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.</li> </ul>  <p>Шингэн хог хаягдал:</p> <p>Шингэн хог хаягдлын тооцоогоор хоногт 68.22 м<sup>3</sup>, жилд нийт хэрэглэх усны хэмжээ 24900.3 м<sup>3</sup>/жил, үүнээс 70%-ийг хаягдал ус гэж үзвэл 17430.21 м<sup>3</sup>/жил болно. Төслөөс гарсан бохир усыг бага оврын цэвэршүүлэх байгууламж байгуулна.</p> <p>Хийн хаягдал:</p> <p>Цогцолборын хийн хаягдал үүсэх эх үүсвэрүүд гэвэл</p>



		автомашины утаа, тээврийн хэрэгслийн тоосжилт зэрэг байна.
	2.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- <b>Тухайн жилийн төсөв 480,000.0 төг</b></li> <li>- Эко байр сууцны үйлчилгээнд энгийн нүхэн жорлонг ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий био жорлонтой байна.</li> <li>- “Хог хаягдал хадгалах зориулалтын цэг”-ийг байр сууц, хоолны газраас 60 м-с багагүй зайд бие засах газраас тусад нь, зонхилох доод зүгт байрлуулж, салхинд хийсгэхгүй байх нөхцлийг бүрдүүлсэн, хөрсөнд шингээлт үүсэхээс хамгаалсан байх</li> <li>- Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх</li> <li>- Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулах, Байр сууц бүрт орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх</li> <li>- Эдэлбэр газар, түүний эргэн тойрны хариуцан хамгаалах талбайг хог хаягдалгүй, цэвэр цэмцгэр байлгах</li> <li>- Нэг удаагийн хэрэглээний зүйлээс татгалзаж, дахин ашиглагдах материалаар хийсэн эд зүйлс хэрэглэх</li> </ul>

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

<b>д/д</b>	<b>Мэдээллийн төрөл</b>	<b>Мэдээлэл оруулах багана</b>
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	6,960,000.0 төг
	2. Хог хаягдлын менежмент	740,000.0 төг
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	2,300,000.0 төг
	4. Ногоон байгууламжийн арга хэмжээний төсөв / биологийн/	2,310,000.0 төг
	5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	--*--
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	1,000,000.0 төг
	7. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй.
	8. Осол эрсдлийн менежмент	---*--
	9. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	610,000.0 төг

## ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

• Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

• Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	<b>Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл</b>  1. Тосгон 2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт) 3. Хог хаягдлын цэгийн байршил 4. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил 5. Биологийн нөхөн сэргээлтийн талбай 6. Гүний худгийн байршил	

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ  
НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэх баганад “**тодорхойлсон**”, “**тодорхойлоогүй**” “**хамааралгүй**” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.

- Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны мэргэжилтэн дүгнэлт гаргана.

